56

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.27 № 42

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

Цагаандэл Уул - Өлзий боомтын
бүтээн байгуулалтын талаар

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутагт Цагаандэл Уул - Өлзий боомт нээхийг Өмнөговь аймгийн Даланзадгад, Хүрмэн, Номгон, Баяндалай, Ханхонгор сумын иргэд эсэргүүцэж буй талаар санал, гомдлоо удаа дараа ирүүлсээр байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Цагаандэл Уул - Өлзий боомтын бүтээн байгуулалттай холбоотойгоор БНХАУ-ын талтай байгуулсан гэрээ, хэлэлцээр холбогдох баримт бичгийн талаар мэдээлэл, бүтээн байгуулалтын явц, олгосон санхүүжилтийн дүнгийн талаар,

2. Боомтын ТЭЗҮ, байгаль орчны нарийвчилсан төлөвлөгөө, үнэлгээний тайлан, усны менежментийн төлөвлөгөөний талаар, үүнтэй холбоотой байгуулсан бүх гэрээ, хэлцэлийн дэлгэрэнгүй мэдээлэл,

3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр албан даалгаварт “Цагаандэл-Уул боомтын үндсэн болон нэмэлт байгууламжийн төвлөрсөн цахилгаан хангамжийг дотоодын эх үүсвэрээс хангаж, дулаан хангамжийн нам даралтын зуухыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг үе шаттай зохион байгуулах арга хэмжээ авах” гэж заасантай холбогдуулан боомтын байгууламжийг цахилгаан хангамжтай холбох болон усаар хангах хөрөнгө оруулалтын эх үүсвэр, холбогдох тайлан судалгаа, ажлын гүйцэтгэл, хариуцаж буй хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний талаар,

4. Тус бүтээн байгуулалтын хүрээнд байгуулсан зөвлөх үйлчилгээний, ажил гүйцэтгэх болон холбогдох бүх гэрээ, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийн хамт,

5. Боомт руу холбох 270 км авто замын концессийн гэрээ, үнийн дүн болон ажлын гүйцэтгэлийн явц, гэрээний хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээлэл,

2024000072

6. Өмнийн говийн хөгжлийн зөвлөлийн боомтын асуудлаар хэлэлцсэн санал, дүгнэлт зэрэг дэлгэрэнгүй мэдээллүүд болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.МӨНХБАЯСГАЛАН